

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажилд гүйцэтгэгч сонгон шалгаруулах тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэ зөвлөх үйлчилгээний зорилго нь 2021 оны хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулалтыг захиалагчаас боловсруулсан судалгааны арга зүй, ажлын даалгаварын дагуу хийж, мэдээллийн бааз үүсгэн, гэрээний хугацаанд хүлээлгэн өгөх болно.
3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй;
 - ✓ Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай;
 - ✓ Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны асуудлын хүрээнд бүс нутаг, улсын хэмжээнд мэдээлэл цуглуулалт гүйцэтгэж, судалгааны дүн шинжилгээ хийсэн туршлагатай; */Захиалагчийн тодорхойлолт ирүүлэх/*
 - ✓ Мэдээлэл цуглуулалт хийж гүйцэтгэх хангалттай туршлага бүхий хүний нөөцтэй; */Холбогдох мэдээллийг ирүүлэх/*
 - ✓ Судалгааны багийн ахлах, голлох мэргэжилтнүүд нь хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн асуудлаар мэргэшсэн, туршлагатай байх; */Нотлох бичиг баримтыг ирүүлэх/*
 - ✓ Татварын болон нийгмийн даатгалын байгууллагад өр төлбөргүй байх; */Тодорхойлолт ирүүлэх/*
 - ✓ Санхүүгийн чадавхтай байх; */аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлэх/*
 - ✓ Хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх; */ харилцагч банкны тодорхойлолт ирүүлэх/*
 - ✓ Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүргээ зөрчөөгүй байх. */Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлэх/*
4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.
5. Сонирхсон этгээд мэдүүлгээ **2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 17.00 цагаас өмнө цахим системээр /tender.gov.mn/** ирүүлнэ үү.

**Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо,
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
ерөнхий газрын байр, 5 дугаар давхар,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
Утас 77121286**